



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/572

Мандалговь

Г 2018 оны үйл ажиллагааны үр дүнд
хяналт шинжилгээ хийх ажлын
хэсэг байгуулах тухай Г

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2017 оны А/452 тоот захирамжийн 2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний асуудлын газар, хэлтэс, агентлагууд, сумдын Засаг дарга түүний Тамгын газрын 2018 оны үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Эрдэнэсүрэн (ЗДТГ-ын дарга)
Нарийн бичгийн дарга:	Г.Самданцоодол (ХШҮДАХ-ийн дарга)
Гишүүдэд:	М.Цогзолмаа(ТЗҮХ-ийн дарга)
	А.Ганбат(СТСХ-ийн дарга)
	Б.Түвшинбаяр(ХЭЗХ-ийн дарга)
	Н.Эрдэнэ-Очир(ХОХБТХ-ийн дарга)
	А.Нарантуяа(НБХ-ийн дарга)
	Э.Одончимэг(ХШҮДАХ-ийн ахлах мэргэжилтэн)
	Н.Дэлгэрмаа(ХШҮДАХ-ийн мэргэжилтэн)
	Д.Даариймаа(ХШҮДАХ-ийн мэргэжилтэн)

Хоёр. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлаг, сумдын Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх удирдамж, аргачлалыг боловсруулан батлуулж, ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг ажлын хэсэг (Ц.Эрдэнэсүрэн), ХШҮДАХ-ийн дарга (Г.Самданцоодол) нарт тус тус даалгасугай.

488010741

Гурав. Газар, хэлтэс, агентлагууд болон сумдын Засаг дарга түүний Тамгын газрын үйл ажиллагааны үр дүнд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгөх ажлыг 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 1 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл хугацаанд удирдамж, аргачлалын дагуу чанартай явуулж, дүнг Засаг даргын Зөвлөлийн хуралд 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг ажлын хэсэг т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ


ЗАСАГ ДАРГА **БАТЛАВ** О.БАТ-ЭРДЭНЭ
2018 оны ... сарын ... -ны өдөр

**СУМДЫН ЗАСАГ ДАРГА ТҮҮНИЙ ТАМГЫН ГАЗРЫН 2018 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР ДҮНГ
ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ**

2018.12.20

Зорилго: Монгол улсын Засгийн газар, Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангах, иргэдтэй уулзаж, санал хүсэлтийг хүлээн авч, аймаг орон нутгийн талаар мэдээлэл өгөхөд оршино.

Хугацаа: 2019 оны 01 дүгээр сарын 7-11 -ний өдрийг дуустал

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн: Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн төлөөлөл 4 хүний бүрэлдэхүүнтэй 4 ажлын хэсэг ажиллана.

Нэг. ХШҮ-ний багаас хийж гүйцэтгэх ажлын чиглэл

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ
 - 1.1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт
 - 1.2. Сумын эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт
 - 1.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
 - 1.4. Үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт
2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ
 - 2.1 Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт
 - 2.2 Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагуудын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт
 - 2.3 Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт
 - 2.4 Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт
3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

3.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

3.2 Байгууллагын шударга байдлын түвшний үнэлгээ

3.3 Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалт

3.4 Хэрэглэгчийн үнэлгээ

Хоёр. Үнэлгээ өгөх аргачлал

1. Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 452 дугаар захирамжаар баталсан журмыг баримтална.

Гурав. Авч ирэх зүйл

1. Хяналт шинжилгээ үнэлгээ хийх дээрх үндсэн үзүүлэлт бүрээр ажлын ололт амжилт, дэмжин дэлгэрүүлэх ажлын сайн арга туршлага, оршиж буй дутагдлыг засах талаар тайлан зөвлөмжийг 2 хувь бичиж, 1 хувийг тухайн байгууллагад үнэлгээний нэгдсэн дүн, сумын эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг хавсарган үлдээнэ.
2. Бусад сумдуудад туршлага болохуйц арга барилын талаар мэдээлэл авч ирэх / хүний нөөц, шинэлэг ажил гэх мэт /
3. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнг сумын иргэд, Тамгын газрын ажилтнууд, байгууллагын дарга эрхлэгч нарт танилцуулан тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн авч ирнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

ЗАСАГ ДАРГА **БАТЛАВ** О.БАТ-ЭРДЭНЭ
2018 оны ... сарын ... -ны өдөр

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭС,
АГЕНТЛАГИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ҮР
ДҮНГ ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

2018.12.20

Зорилго: Монгол улсын Засгийн газар, Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангах, санал хүсэлтийг хүлээн авч, аймаг орон нутгийн талаар мэдээлэл өгөхөд оршино.

Хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 25-31-ний өдрийг дуустал

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн: Аймгийн ЗДТГ-аас хэлтсүүдийн төлөөлөл 4 хүний бүрэлдэхүүнтэй 4 ажлын хэсэг ажиллана.

Нэг. ХШҮ-ний багаас хийж гүйцэтгэх ажлын чиглэл

1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

- 1.1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт
- 1.2. Аймгийн эдийн засаг нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн агентлагт холбогдолтой заалтын биелэлт
- 1.3. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
- 1.4. Яамны сайдтай Аймгийн засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилт

2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ

- 2.1 Аймгийн Засаг даргаас агентлагийн дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт /Тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт/
- 2.2 Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт
- 2.3 Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт
- 2.4 Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт

3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ

- 3.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ
- 3.2 Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, шилэн данс хөтлөлт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтад

3.3 Шударга байдлын түвшний үнэлгээ

3.4 Хэрэглэгчийн үнэлгээ

Хоёр. Үнэлгээ өгөх аргачлал

1. Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхдээ Засгийн газрын 89 дүгээр тогтоол болон аймгийн Засаг даргын 452 дугаар захирамжаар баталсан журмыг баримтална.

Гурав. Авч ирэх зүйл

1. Хяналт шинжилгээ үнэлгээ хийх дээрх үндсэн үзүүлэлт бүрээр ажлын ололт амжилт, дэмжин дэлгэрүүлэх ажлын сайн арга туршлага, оршиж буй дутагдлыг засах талаар тайлан зөвлөмжийг 2 хувь бичиж, 1 хувийг тухайн байгууллагад эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг хавсарган үлдээнэ.
2. Бусад агентлагуудад туршлага болохуйц арга барилын талаар мэдээлэл авч ирэх
3. Хяналт шинжилгээ үнэлгээний дүнг хэлтэс агентлагийн хамт олонд танилцуулан тэдгээрийн санал хүсэлтийг хүлээн авч ирнэ.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС